

ЗӨВШӨӨРӨВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Д.ОЧИРБАТ



БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НҮҮР АМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Б.БАЯРЧИМЭГ



**ШҮДНИЙ ЭМЧИЙН
“НҮҮР АМНЫ СОГОГ ЗАСАЛ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

ИНДЕКС: S(r) 091103
ХУГАЦАА: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2024 он

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

НҮҮР АМ СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨӨЛӨЛ:

Б.Энхбаатар	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Анагаах ухааны магистр
Ч.Гантөмөр	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Анагаах ухааны доктор

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨЛ:

Б.Амарсайхан	Нүүр Ам Судлалын төв эмнэлгийн зөвлөх эмч, Анагаах ухааны доктор, профессор
Б.Сапаар	Нүүр Ам Судлалын Төв эмнэлгийн эмч, Тэргүүлэх зэргийн эмч, Анагаах ухааны доктор

НИЙГЭМЛЭГ ХОЛБООДЫН ТӨЛӨӨЛӨЛ:

Т.Учрал	Монголын Шүдний Мэргэжилтнүүдийн Холбооны Ерөнхийлөгч, Ахлах зэргийн эмч, Анагаах ухааны Магистр
---------	--

ХЯНАСАН

Н.Дашдондов	Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Салбарын хүний нөөцийн сургалт, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл Мэндийн Хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны үндсэн мэргэшлийн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

НҮҮР АМНЫ ИХ ЭМЧИЙН “НҮҮР АМНЫ СОГОГ ЗАСАЛ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын ЭМЯ эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагааны чадамжийг сайжруулах зорилгоор гадаад ба дотоодын байгууллагуудтай хамтран тусгай хөтөлбөр боловсруулан үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний нэг хэсэг нь төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагааг сайжруулж боловсронгуй болгох асуудал юм. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 06 сарын 03 өдрийн 01 тоот тогтоолоор “Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлага”-ыг баталсан бөгөөд Монгол улсын хэмжээнд үндсэн мэргэшлийн сургалтын эрх бүхий байгууллагууд тухайн мэргэшлийн хүрээнд Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн баталсан нэг хөтөлбөрийн дагуу сургалт явуулах боломж бүрдсэн юм.

Нөгөө талаар шүд, эрүү нүүрний эрхтний бүтэц ба үйл зүйг хиймэл эрхтнээр сэргээх нүүр амны согог заслын шинжлэх ухаанд орчин үеийн физик, хими, биологи, био-инженерчлэл ба биотехнологийн ололт нээлтүүд гүн нэвтэрч оношилгоо, эмчилгээнд CAD/CAM, 3D принтинг, виртуал орчинд шүдэлбэрийг хийх технологи нэвтэрч, үйлчлүүлэгчдийн зүгээс зөвхөн согогийг нөхөн сэргээх бус гоо сайхан, амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлага өндрөөр тавигдаж байна. Энэ нь нүүр амны согог заслын эмч мэргэжилтэнд шүд, эрүү-нүүрний эрхтнийг авах бус хадгалж сэргээх дэлхий нийтийн чиг хандлагыг барих, орчин үеийн биоматериал ба биотехнологийн ололт хөгжилтэй цаг тухайд нь танилцаж эмнэл зүйн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зүй ёсны шаардлага тулгараад байна.

Төрийн захиргааны төв байгууллага ЭМЯ-ы төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын үйл ажиллагааг сайжруулах бодлого, нүүр амны согог заслын клиникт эмч нарт үйлчлүүлэгчдийн зүгээс өдөр тутам шаардаж буй хэрэгцээ шаардлага нь Нүүр амны согог засал судлалын үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үндэслэл боллоо.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Нүүр амны согог заслын эмчийн мэргэшүүлэх сургалтад хүн амын дунд тохиолдох шүдний хатуу эдийн ба шүдний эгнээний согог, бүрэн шүдгүйдэл, эрүү-нүүрний согогийг оношлох, эмчлэх, урьдчилсан сэргийлэх онолын мэдлэг, чадвар, хандлага бүхий нүүр амны согог заслын чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ба гурав дахь шатлалын эмнэлэгт бие даан ажиллах чадвартай эмч бэлтгэж нүүр амны согог заслын

тусламж үйлчилгээний хүртээмж ба чанарыг сайжруулах, монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ухамсарласан, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх онолын өндөр мэдлэгтэй, эрдэм шинжилгээ, судалгаа, нотолгоонд суурилсан, инноваци бүхий мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн байна.

ДӨРӨВ. ЦОГЦ ЧАДАМЖ

Чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, мэргэжлийн тусламж үйлчилгээгбие даан гүйцэтгэж чаддаг болно.

Үүнд:

1. Нүүр амны согог заслын эмч байх (Prosthodontist)
2. Мэргэжлийн байх (Professional)
3. Суралцагч байх (Learner)
4. Харилцагч байх (Communicator)
5. Хамтрагч байх (Collaborator)
6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (Community health advocate)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader)

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Хөтөлбөр нь доорхи зорилтыг ханган биелүүлнэ.

Нэг. Нүүр амны согог заслын эмч байх (Prosthodontist)

- Хоршихуйн тухай орчин үеийн ойлголт, тэдгээрийг тодорхойлох эмнэл зүйн ач холбогдол, голлосон хоршихуй, төвийн харьцаа, хоншоор эрүүний босоо ба хэвтээ харьцааг эмнэл зүйд тодорхойлж, оношилгоо ба эмчилгээнд хэрэглэх мэдлэг ба чадвартай байх.
- Нүүр амны согог заслын эмнэл зүйд үйлчлүүлэгчийг шинжлэх, оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, тавиланг тодорхойлох мэдлэг ба чадвартай байх.
- Нүүр амны согог заслын практикт хэрэглэж буй орчин үеийн материалын тухай мэдлэг олгох, шинэ арга технологийг эзэмших.
- Авагддаг ба авагддаггүй шүдэлбэр хийхэд амыг бэлтгэх ерөнхий ба тусгай аргуудын тухай мэдлэгтэй байх.
- Шүдний цөгцний согогийг зоомол, шигтгэмэл, бүрээс ба голонцортой шүдэлбэрээр сэргээх эмнэл зүйн болон урлангийн ажилбарыг (шүдийг засах, ажлын хэв авах, түр шүдэлбэр хийх, ажлын загвар цутгах, үелүүрт суулгах, загваржуулалт хийх, инвестлэх, цутгах, өөлж өнгөлөх, бэлэн болсон шүдэлбэрийг аманд суулгах, зөвлөгөө өгөх, давтан үзлэг хийх) гүйцэтгэх мэдлэг ба чадвартай байх.

- Шүдний эгнээний согогийг хэсгийн авагддаггүй шүдэлбэрээр сэргээх эмнэл зүйн болон урлангийн ажилбарыг (тулгуур шүдийг засах, ажлын хэв авах, түр шүдэлбэр хийх, ажлын загвар цутгах, үелүүрт суулгах, загваржуулалт хийх, инвестлэх, цутгах, өөлж өнгөлөх, бэлэн болсон шүдэлбэрийг аманд суулгах, зөвлөгөө өгөх, давтан үзлэг хийх) гүйцэтгэх мэдлэг ба чадвартай байх.
- Шүдний эгнээний согогийг авагддаг шүдэлбэрээр сэргээх сэргээх эмнэл зүйн болон урлангийн ажилбарыг (оношилгооны загвар шинжих, шүдэлбэрийг зохиомжлох, оношилгооны загвар дээр тусгай хэвний халбага хийх, ажлын хэв авах, ажлын загвар цутгах, хорших дэрлэг бүхий суурь бэлтгэх, хоншоор эрүүний босоо ба хэвтээ харьцааг тодорхойлох, ажлын загварыг үелүүрт суулгах, ажлын загвар дээр тээг хааж хувилах, шүдэлбэрийн лавайн зохиомжийг гаргах, цутгах, металл хийцийг өөлж өнгөлөх, металл хийцийг аманд шалгах, шүд өрөх, шүдэлбэрийн урьдал хийцийг аманд шалгах, тэвшлэх, лавайг хуванцраар солих, өөлж өнгөлөх, бэлэн болсон шүдэлбэрийг аманд суулгах, зөвлөгөө өгөх, давтан үзлэг хийх) гүйцэтгэх мэдлэг ба чадвартай байх.
- Бүрэн шүдэлбэрийг хийх эмнэл зүй болон урлангийн ажилбарын тухай (оношилгооны загвар шинжих, бүрэн шүдэлбэрийн хил хязгаарыг тодорхойлох, тусгай хэвний халбага хийх, ажлын хэв авах, ажлын загвар цутгах, хорших дэрлэг бүхий суурь бэлтгэх, хоншоор эрүүний голлосон харьцааг тодорхойлох, ажлын загварыг үелүүрт суулгах, шүд өрөх, шүдэлбэрийн урьдал хийцийг аманд шалгах, тэвшлэх, лавайг хуванцраар солих, өөлж өнгөлөх, бэлэн болсон шүдэлбэрийг аманд суулгах, зөвлөгөө өгөх, давтан үзлэг хийх) мэдлэг ба чадвартай байх.
- Имплант эмчилгээний төлөвлөгөө боловсруулж ясны эдийн хатингаршил багатай энгийн тохиолдол дээр имплант суулгац суулган имплант тулгуурт бүрээс хийх эмнэлзүйн ба урлангийн ажилбаруудын тухай мэдлэг ба чадвартай байх
- Эрүүний үений эмгэг ба Эрүү нүүрний согогтой болон эрүүний үений эмгэгтэй үйлчлүүлэгчид энгийн хийцтэй чиг ба зэмсэг хийх мэдлэг олгож эмнэл зүйн мэдлэг ба чадвартай байх.

Хоёр. Мэргэжлийн байх (Professional)

- Нүүр ам судлалын болон нүүр амны согог засал судлалын шижлэх ухааны өндөр мэдлэгтэй, тухайн эрүүл мэндийн байгууллагад өөрийн мэргэжлээр хувь нэмрээ оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх
- Үйлчлүүлэгчийг хувь хүний хувьд хүндэтгэн, хамгийн оновчтой зөв шийдвэрийг гаргахын төлөө ажиллах
- Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садны хүнтэй хүндэтгэлтэй харьцах

Гурав. Суралцагч байх (Learner)

- Өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтанд байнга хамрагдах
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх

- Хамтран суралцагч эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах

Дөрөв. Харилцагч байх (Communicator)

- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садын хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харьцах
- Үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах
- Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй зөвлөлдөх

Тав. Хамтрагч байх (Collaborator)

- Тухайн орон нутгийн болон үйлчлэх хүрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцох, хамтран ажиллах
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах

Зургаа. Эрүүл мэндийн зөвлөгч байх (Community health advocate)

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Долоо. Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader)

- Мэргэжлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалт үргэлжлэх нийт хугацаа 2 жил буюу 88 долоо хоног байна.
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн шийдвэрээр “Нүүр амны мэс засал судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллага нь энэхүү сургалт явуулах үндсэн байгууллага байна.
- Хөтөлбөрийн зарим агуулгын явуулах хангалттай орчин бүрдүүгүй тохиолдолд мэргэжлийн хичээлийн тойролтуудын 30 хүртэлх хувийг эрүүл мэндийн бусад байгууллагыг түшиглэн явуулж болно.
- Сургалт явуулах үндсэн байгууллага ба сүлжээ эмнэлгийн тасаг, амбулатори дээр суралцаж ажиллах хугацаандаа “Нүүр амны согог засал судлалын резидент эмч нарын үндсэн ба сүлжээ эмнэлгүүдийн нүүр амны согог заслын кабинетэд ажиллах журам”, “Резидент эмч нарын амралт, чөлөө, таслалт, хоцролтыг тооцох, зохицуулах журам”-ыг мөрдлөг болгоно.

- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг сургалт эрхлэх алба, тасаг боловсруулна.
- Суралцагч нь сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууц, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, жендерийн тэгш байдалтай холбоотой хууль, журам, Эмнэлгийн эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, радиологи оношилгооны аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд (orientation) заавал хамрагдана.

6.2. Зайлшгүй таниж мэдэх, суралцах шаардлагатай эмнэлзүйн ажилбар ба гардан үйлдэл

Сургалтын төгсгөлд ажлын байранд ганцаараа бие даан тусламж үйлчилгээ үзүүлж чадах төвшинд хүрэхийн тулд эмнэлзүйн сургагч багшийн хяналтан дор нүр амны согор заслын кабинет ба тасгийн үйлчлүүлэгчид эмчилгээ хийх явцдаа дараах эмнэлзүйн ажилбаруудыг бие даан гүйцэтгэх туршлага хуримтлуулсан байна.

6.2.1 Эмнэлзүйн ажилбарууд (Аль ч тойролтонд тохиолдох)

1. Хэсгийн авагддаг шахмал хуванцар шүдэлбэрийн эмнэлзүй (Removable partial interim denture)
2. Хэсгийн авагддаг цутгамал шүдэлбэрийн эмнэлзүй (Removable partial denture)
3. Бүрэн шүдэлбэрийн эмнэлзүй (Complete denture)
4. Метал, шаазан зоомлын эмнэлзүй (Inlay, Onlay)
5. Голонцор тулгуурын эмнэлзүй (Post and Core)
6. Метал бүрээсний эмнэлзүй (Cast crown)
7. Метал шаазан бүрээсний эмнэлзүй (PFM crown)
8. Дан шаазан бүрээсний эмнэлзүй (PFZ crown)
9. Гүүрэлсэн шүдэлбэрийн эмнэлзүй (Fixed partial denture)
10. Имплант тулгуурт шүдэлбэрийн эмнэлзүй (Implant treatment)
11. Эрүүний үений эмгэгийн эмнэлзүй (TMJ treatment)
12. Эрүү нүүрний согор заслын эмнэлзүй (Maxillofacial Prosthodontic treatment)

6.2.2 Гардан үйлдлийн жагсаалт

1. НАСЗ клиникт өвчтөн шинжлэх, баримт бүрдүүлэх, үзлэгийн карт хөтлөх, захиалгын хуудас бөглөх (Patient record and examination procedure)
2. Авагддаг, авагддаггүй шүдэлбэрийн эмчилгээний төлөвлөгөө боловсруулах (Treatment planning for Fixed and removable prosthesis)
3. Альгинат хэвний материалаар эрүү хоншоороос хэв авах (Impression taking)
4. Нүүр нумын шилжүүлэг хийж оношилгооны загвар шинжлэх (Facebow record and transfer)
5. Артикуляторын тохиргоо хийж мэдээллийг лабораторид дамжуулах (Articulator setting)

6. Хэсгийн шүдгүйдлийн үед хоншоор ба эрүүний хэвтээ ба босоо харьцааг тодорхойлох (Maxillomandibular vertical and horizontal relationship record for removable partial denture)
7. Авагддаг шүдэлбэрийг аманд тааруулах (Denture adjustment)
8. Хяналтын давтан үзлэг (Follow up)
9. Цутгамал метал суурьтай авагддаг шүдэлбэрийн хэв авалт (Impression taking for RPD)
10. Праллелометрийн хэмжилт хийж RPD зохиомж зурах (Surveying)
11. Метал суурь ба бэлэн болсон шүдэлбэрийг аманд тааруулах (Metal framework adjustment)
12. Үүдэн бүлгийн шүд засах (Tooth preparation for anterior teeth)
13. Бага араа бүлгийн шүд засах (Tooth preparation for premolars)
14. Араа бүлгийн шүд засах (Tooth preparation for molar)
15. Цөгцний ба хэсгийн согогийн үед эластомер материалаар хэв авах (Impression taking by elastomers)
16. Түр бүрээс, түр шүдэлбэр бэлтгэх (Making temporary crown and interim denture)
17. Бүрээс наах (Temporary or permanent cementation)
18. Бүрэн шүдэлбэрийн хэв авах (Primary and Final impression taking for Complete denture)
19. Бүрэн шүдэлбэрийн тусгай халбага эмжих (Impression molding technique)
20. Бүрэн шүдэлбэрийн ажлын загвар хайрцаглаж цутгах (Beading and Boxing master model)
21. Бүрэн шүдгүйдлийн үед хоншоор ба эрүүний хэвтээ ба босоо харьцааг тодорхойлох (Maxillomandibular relationship record for Complete denture)
22. Бүрэн шүдэлбэрийг аманд тааруулах, хоршихуйн тохиргоо хийх (Denture setting and occlusal adjustments)
23. Имплантын хэв авах Closed-tray апрачлал (Closed tray method for Implant impression)
24. Имплантын хэв авах Open-tray апрачлал (Open tray methods for Implant impression)
25. Бүрээсийг имплантанд тааруулах, бэхлэх апрачлал (Implant crown cementation and screw retaining methods) 235
26. Эрүүний эмгэгийн үед чиг бэлтгэх (Splint therapy for TMD)
27. Эрүү нүүрний согор заслын зэмсэг бэлтгэх (Making Maxillofacial prosthesis)

6.3 Онолын мэдлэг сайжруулах

Хэлэлцүүлэг / Journal review (1 сард 5-аас дээш өгүүлэл)

- Резидент эмч удирдагч багштайгаа хамтран сургалтын болон шинжлэх ухааны өгүүллүүдийг сонгон авч уншиж бэлтгээд нийт хамт олны дунд хэлэлцүүлнэ
- Резидент эмч нь өөрийн сонгон авсан өгүүллийг багш болон бусад резидент эмч нарт 15 мин хугацаанд танилцуулан тайлбарлаж, хэлэлцүүлнэ.
- Сонгон авсан өгүүлэл нь сүүлийн 3 жилийн хугацаанд хэвлэгдсэн байх шаардлага тавина.

Номын хэлэлцүүлэг / Book review (Сард 4 удаа)

Нэгдүгээр дамжааны резидент эмч нар

- V Rangarajan, TV Padmanabhan. Textbook of Prosthodontics. Elsevier 2018
- Kratochvil's Fundamentals of Removable Partial Dentures. Quintessence Publishing Co, Inc 2019

Хоёрдугаар дамжааны резидент эмч нар

- Rosenstiel, Land, Fujimoto CONTEMPORARY FIXED PROSTHODONTICS. Elsevier 2006
- Arthur O. Rahn, John R. Ivanhoe, Kevin D. Plummer Textbook of Complete Dentures. People's Medical Publishing House 2020

Резидент эмч нар тухайн номын хуваарилж авсан бүлгийг уншиж хэлэлцүүлэгт бэлтгэн ирнэ. 1 цагийн хугацаанд удирдагч багш нар болон бусад резидентүүдэд номын бүлгийн агуулгыг танилцуулан, асуултанд хариулан хэлэлцүүлэг өрнүүлнэ.

Тохиолдлын хэлэлцүүлэг / Case discussion (Эмнэлзүйн баг бүр сургалтын явцад 2 удаа)

- Резидент эмч нар сургалтын явцад эмчилсэн болон эмчилгээнд оролцсон үйлчлүүлэгчдийн мэдээлэл болон эмчилгээний түүхийг багтаасан хавтас бэлтгэнэ
- Хавтсанд үйлчлүүлэгчийн карт, эмчилгээний төлөвлөгөө, эмчилгээний хяналтын хуудас, хийсэн ажилбарыг нотлох зургууд, шүдэлбэрийн захиалгын хуудас, төлбөр төлсөн баримт байна
- Эмнэлзүйн тохиолдлыг сургалтын албанаас өгсөн загварын дагуу бэлтгэнэ.
- Бэлтгэсэн тохиолдлыг 15 мин хугацаанд эмнэлзүйн багш нар ба бусад резидентүүдэд танилцуулна.
- Асуулт хариулт, санал шүүмжлэлийн хугацаа 15 мин байна.

Бусад хэлэлцүүлэг

- Нүүр Амны Согог Заслын тэнхим тасаг ба бусад тэнхим тасгаас онцгой шаардлагатай гэж үзвэл багш нарыг лекц уншуулахаар урина. Үүнийг координатор багш зохицуулна.
- Хэрэв резидент эмч Олон улсын хуралд оролцох шаардлага үүсвэл хөтөлбөрийн удирдагч ажиллах хуваарийг зохицуулна.

Загвар 1

Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

	Сургалтын хэлбэр	Сурагцлагч эмчийн тоо	Үргэлжлэх хугацаа давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
1	Эмнэлзүйн ажиглалт	5	4 цаг 7 хоногт 5 удаа	НАСЗ тасаг НАСЗ кабинет	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сургагч багш
2	Эмнэлзүйн ажилбарт туслах	1-2	2 цаг 7 хоногт 3 удаа	НАСЗ тасаг НАСЗ кабинет	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сургагч

	эмчээр оролцох					багш, бусад эмч
3	Лабораторид ажиллах	5	1 цаг 7 хоногт 1 удаа	НАСЗ лаборатори	Үйлчлүүлэгчийн ажлын загвар	Шүдний техникч
4	Бие даан ажилбар гүйцэтгэх	3	2 цаг 7 хоногт 3 удаа	НАСЗ тасаг НАСЗ кабинет	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сургагч багш, бусад эмч
5	Имплантын мэс засалд оролцох	3	2 цаг 1 сард 1 удаа	Имплантын өрөө	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн сургагч багш

Загвар 2

Танхимын сургалт (On-the-Job Training)

	Аргачлал	Суралцагчийн тоо	Үргэлжлэх цаг Давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэх үн	Хамтрагч
1	Бие даалт	1	Тохиромжтой цагт	Гэртээ, сургалтын танхим	Номын сан, интернэт	Суралцагч, хамтран суралцагч
2	Лекц	10 хүртэл	7 хоногт 1 удаа 1-2 цаг	Сургалтын танхим	Танилцуулга Presetation	Эмнэлзүйн сургагч багш
3	Журнал клуб буюу хэлэлцүүлэг	10 хүртэл	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын танхим	Эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, мэргэжлийн гадаад сэтгүүл	Суралцагч, эмнэлзүйн сургагч багш
4	Симуляци, дуураймал орчин	1-2 ээлжээр	2 цаг 14 хоногт 1 удаа	Фантомын өрөө	Typodont	Эмнэлзүйн сургагч багш

Загвар 3

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
8:30 – 12:30	Эмнэлзүйн ажиглалт	Эмнэлзүйн ажилбарт туслах эмчээр оролцох	Бие даан ажилбар гүйцэтгэх	Эмнэлзүйн ажилбарт туслах эмчээр оролцох	Эмнэлзүйн ажиглалт

13:30 – 14:30	Лабораторид ажиллах	Лабораторид ажиллах	Журнал клуб	Лабораторид ажиллах	Бие даалт
14:30 – 16:00	Бие даалт	Лекц	Бие даалт	Номын хэлэлцүүлэг	Имплантын мэс засалд оролцох

ТОЙРОЛТЫН ХУВААРЬ

Эмнэлзүйн тойролтууд	Хугацаа	Тойролт хийх эмнэлгүүд
Нүүр Амны Согог Заслын суурь ойлголт олгох сургалт	12 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага
Авагддаг шүдэлбэрийн эмнэлзүй	16 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага, Сүлжээ эмнэлгүүд
Авагддаггүй шүдэлбэрийн эмнэлзүй I	16 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага, Сүлжээ эмнэлгүүд
Бүрэн шүдэлбэрийн эмнэлзүй	12 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага, Сүлжээ эмнэлгүүд
Авагддаггүй шүдэлбэрийн эмнэлзүй II	12 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага, Сүлжээ эмнэлгүүд
Имплант тулгуурт шүдэлбэрийн эмнэлзүй	12 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага, Сүлжээ эмнэлгүүд
Эрүүний үений эмгэгийн согог заслын эмчилгээ	4 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага, Сүлжээ эмнэлгүүд
Эрүү нүүрний согог засал	4 долоо хоног	Нүүр Амны Согог Засалч эмчийн үндсэн мэргэшлийн сургалт явуулах эрх бүхий байгууллага, Хавдар судлалын үндэсний төвийн Хүзүү толгойн мэс заслын тасаг

6.4 Тойролтын агуулга

Нүүр Амны Согог Заслын суурь ойлголт олгох сургалт (Тойролт 1)

- Эрүүний хөдөлгөөн ба биомеханик
- Хоншоор эрүүний харьцаа ба Хоршихуйн тухай орчин үеийн онол
- Хоршихуй, хоншоор эрүүний босоо ба хэвтээ харьцааг тодорхойлох
- Нүүр нумын шилжүүлэг хийж, хагас тохируулгатай үелүүрт оношилгооны ба ажлын загварыг суулгаж хоршилтыг шинжлэх

- Рентген цацрагийн тухай үндсэн ойлголт, цацрагийн хамгаалалт
- Рентген цацрагийн физик шинж чанар, ионжуулагч үйлчилгээ, хамгаалалтын хэрэгслүүд, хэмжих багажууд, дозиметр
- Рентген тасаг кабинетын зохион байгуулалт, ажиллах журам
- Нүүр амны дүрс оношилгооны үндэс
- НАСЗ-ын эмнэл зүйд үзлэгийн карт хөтлөх, үйлчлүүлэгчээс асуумж авах
- НАСЗ-ын эмнэл зүйд үйлчлүүлэгчид нүүрний ба амны үзлэг хийх
- Оношийн таамаглал гаргах, эмнэл зүйн дэлгэрэнгүй онош тавих
- Эмчилгээний төлөвлөгөө боловсруулах, тавиланг тодорхойлох
- Шүдийг засахад мэдээ алдуулах арга техник
- Шүд авах үед ба дараа гарах хүндрэлүүд, түүнээс сэргийлэх
- Шүдний эмнэлэгт яаралтай тусламж үзүүлэх арга барил
- Авагддаг шүдэлбэр хийхэд ясны ургацгийг мэс заслын аргаар тайрах, шилжих нугалаасыг гүнзгийрүүлэх, сул хөдөлгөөнтэй салстыг тайрах мэс заслын аргууд
- Шүдний тулгуур эдийн эмгэгтэй үйлчлүүлэгчийг шинжлэх (шүд-буйлны эмгэг хөндийн гүнийг тодорхойлох, буйлны шамралт ба ясны эдийн шимэгдлийг тодорхойлох, шүдний хөдөлгөөнийг тодорхойлох)
- Шүдний тулгуур эдийн эмгэгтэй үйлчлүүлэгчид шүдэлбэр хийх
- Авагддаггүй ба авагддаг шүдэлбэрийн шүдэлбэрийн тулгуур ба бусад шүдэнд үзүүлэх сөрөг нөлөөг хянах
- Голомцортой шүдэлбэр хийхэд шүдний сурвалжийн сувгийг бэлтгэх
- Амны салстын эмгэгтэй үйлчлүүлэгчид шүдэлбэр хийх
- Авагддаг шүдэлбэрийн амны салстад үзүүлэх нөлөө

Авагддаг шүдэлбэрийн эмнэлзүй (Тойролт 2)

- Шүдний эгнээний согогтой үйлчлүүлэгчид үзлэг хийж онош тавих, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Шахмал ба уян авагддаг шүдэлбэрийг зохиомжлох онолын үндэс
- Авагддаг шүдэлбэр хийхэд амыг бэлтгэх
- Ажлын хэв авах
- Шүдэлбэрийн урьдал хийцийг шалгах
- Бэлэн болсон шахмал шүдэлбэрийг аманд суулгах, эрүүл ахуйн ба хэрэглэж хэвшүүлэх тухай зөвлөгөө өгөх
- Цутгамал авагддаг шүдэлбэрийг зохиомжлох онолын үндэс, биомеханик
- Цутгамал авагддаг шүдэлбэр хийхэд амыг бэлтгэх
- Кеннедийн ангилал тус бүрт зориулан цутгамал авагддаг шүдэлбэрийн зохиомж зурах
- Тусгай хэвний халбага хийх
- Тулгуур шүдэнд даравчийн ором, чиглүүлэгч хавтгай засах, загварыг параллелометр дээр шинжлэх, тулгуур шүдний бүслүүрийн шугамыг шилжүүлэх, тээг засах
- Ажлын хэв авах
- Ажлын загвар цутгах

- Шүдэлбэрийн металл хийцийг аманд суулгах
- Цутгамал авагддаг шүдэлбэрийн урьдал хийцийг аманд шалгах
- Бэлэн болсон цутгамал авагддаг шүдэлбэрийг аманд суулгах, эрүүл ахуйн ба хэрэглэж хэвшүүлэх талаар зөвлөгөө өгөх

Авагддаггүй шүдэлбэрийн эмнэлзүй I (Тойролт 3)

- Шүдний цөгцний согогтой үйлчлүүлэгчид үзлэг хийж, онош тавих, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Зоомол хийх шүдний цөгцөнд хөндий засах онолын үндэс, хэрэглэх багаж, тоног төхөөрөмж
- Зоомол хийх шүдний цөгцөнд MO ба OD хөндий засах
- Бүрээс хийх шүдний цөгцийг засах онолын үндэс, хэрэглэх багаж, тонтог төхөөрөмж
- Дан цутгамал, металл-шаазангийн хосолмол ба дан шаазан бүрээсний засалт хийх
- Түр бүрээсний зориулалт, хийх аргууд
- Шүдний цөгцийг голонцортой шүдэлбэрээр сэргээх онолын үндэс
- Голонцортой шүдэлбэр хийх шүдний сурвалжийг хэв авахад бэлтгэх
- Шүдний өнгө үзэх
- Авагддаггүй шүдэлбэр хийхэд ажлын хэв авах
- Түр бүрээс хийж түр наах
- Бэлэн болсон авагддаггүй шүдэлбэрийг аманд тааруулах, наах, эрүүл ахуйн, хэрэглэж хэвшүүлэх тухай зөвлөгөө өгөх

Бүрэн шүдэлбэрийн эмнэлзүй (Тойролт 4)

- Бүрэн шүдгүй үйлчлүүлэгчийг шинжлэх, оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Бүрэн шүдэлбэрийг тогтоох онолын үндэс
- Бүрэн шүдгүй хоншоор ба эрүүний анхдагч хэвийг авах
- Оношилгооны загвар цутгах
- Тусгай хэвний халбага хийх
- Бүрэн шүдгүй хоншоор эрүүний хэвийг авахад тусгай хэвний халбагыг эмжих
- Бүрэн шүдгүй хоншоор ба эрүүний ажлын хэв авах
- Бүрэн шүдгүй хоншоор ба эрүүний ажлын загварыг хайрцаглаж цутгах
- Хоншоор эрүүний босоо ба хэвтээ харьцааг тодорхойлох
- Бүрэн шүдэлбэрийн урьдал хийцийг аманд шалгах
- Бэлэн болсон бүрэн шүдэлбэрийг аманд суулгах, эрүүл ахуйн ба хэрэглэж хэвшүүлэх тухай зөвлөгөө өгөх
- Давтан үзлэг хийх
- Бүрэн шүдэлбэрийн суурийн таарамжийг засах

Авагддаггүй шүдэлбэрийн эмнэлзүй II (Тойролт 5)

- Шүдний эгнээний согогтой үйлчлүүлэгчид үзлэг хийж, онош тавих, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Гүүрэлсэн шүдэлбэрийн тулгуурыг сонгох онолын үндэс, тулгуур шүдийг засах зарчим, анхаарах зүйлс
- Тусгай хэвний халбага хийх
- Тулгуур шүдийг засах
- Гүүрэлсэн шүдэлбэрийн хэв авахад анхаарах асуудлууд
- Шүдний өнгө тааруулах
- Түр гүүрэлсэн шүдэлбэр хийж түр наах
- Гүүрэлсэн шүдэлбэрийн циркон ба метал хийцийг аманд шалгах
- Бэлэн болсон гүүрэлсэн шүдэлбэрийг шалгах, аманд суулгах, эрүүл ахуйн ба хэрэглэж хэвшүүлэх тухай зөвлөгөө өгөх

Имплант тулгуурт шүдэлбэрийн эмнэлзүй (Тойролт 6)

- Яс, ясны бүтэц, хэмжээ, чанар, ясны остеоинтеграцийн тухай ойлголт
 - Имплантын бүрэлдэхүүн хэсгүүд ба тэдгээрийн үүрэг
 - Имплантын мэс ажилбарын тухай ойлголт
 - Имплантын согог заслын ажилбарын тухай ойлголт
 - Имплантын хэв авах аргачлалууд
 - Имплантын хоршилт, түүний онцлогууд
 - Имплант эмчилгээний хүндрэл
- Имплант тулгуурт бүрэн шүдэлбэрийн тухай (Overdenture)

Эрүүний үений эмгэгийн согог заслын эмчилгээ (Тойролт 7)

- Эрүүний үений эмгэгтэй үйлчлүүлэгчийг шинжлэх, оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Эрүүний үений эмгэгийн эмчлэх аргууд тэдгээрийн давуу болон сул тал
- Эрүүний үений эмгэгийн чиг эмчилгээ
- Ам ангайлт хязгаарлагдсан үйлчлүүлэгчээс хэв авах
- Чигийг шууд бус аргаар хийх
- Чигийг аманд суулгаж хоршилтыг тааруулах
- Чиг зүүсэн үйлчлүүлэгчид амны эрүүл ахуйн ба чигийг хэрэглэж хэвшүүлэх тухай зөвлөгөө өгөх
- Давтан үзлэг хийх

Эрүү нүүрний согог засал (Тойролт 8)

- Эрүү-нүүрний согогтой үйлчлүүлэгчийг шинжлэх, оношлох, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Нүүрний хэв авах
- Нүүрний загвар цутгах
- Бэлэн болсон хиймэл эрхтнийг суулгах
- Тагнайн хамгаалах ялтас хийх

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

- 7.1. Сургалт эрхлэх байгууллага нь ажлын байрны сургалтыг удирдан явуулах эмнэлзүйн сургагч багш нарыг томилон хуваарилна. Сургалтын явц, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (Career plan) талаар зөвлөлдөх, хяналт тавих сургалт хариуцагч (Mentor) -ыг сургалт эрхлэх байгууллага томилон ажиллуулна. Сургалт хариуцагч нь сар бүр 1 удаа тогтмол уулзалт зохион байгуулж суралцагч эмч нартай мэдээлэл солилцож үнэлгээтэй танилцана.
- 7.2. Тойролт бүрт суралцагч эмчийг сүлжээнд нэгдсэн эмнэлгүүдэд илгээж тойролтын хугацаанд хэрэгжүүлэх зорилтыг танилцуулна. Тойролт дуусахад тойролт удирдсан багштай ярилцлага хийж сургалтын үнэлгээ, зөвлөгөө авна.
- 7.3. Үнэлгээний арга нь сургалтын явцын үнэлгээ, төгсөлтийн шалгалт гэсэн хоёр хэлбэрээр хийгдэнэ.
 - “Нүүр Амны Согор Засал Судлал” сургалтын төгсгөлд Төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтанд тэнцсэн тохиолдолд Нүүр Амны Согор Засал Судлалын үндсэн мэргэшлийн үнэмлэх олгоно.
 - Явцын буюу ажлын байранд суурилсан үнэлгээ нь дараах аргуудаар үнэлнэ. Явцын үнэлгээ нь нийт үнэлгээний 80 хувиас доошгүй хувийг эзлэнэ.

Ажлын байранд суурилсан үнэлгээ (Work based assessment)

360 хэмийн үнэлгээ (360 degree assessment)

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (professional), манлайлагч байх (leader) чадамжийг үнэлэхэд хэрэглэгдэнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас томилно. Үнэлгээний дүнг суралцагч эмч ба хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө. Хяналтын дэвтрээс ирцийн үнэлгээг сургалтын алба гаргаж нэгтгэнэ.

Mini-CEX / Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini – Clinical Evaluation Exercise)

Ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал таньж мэдэх эмнэлзүйн ажилбараас 5-аас доошгүй ажилбар бүрт 3-аас доошгүй удаа нийт 15-аас цөөнгүй удаа үнэлгээ хийнэ.

Ур чадварыг шууд ажиглан дүгнэх үнэлгээ (Direct Observation of Professional Skills)

Сургалтын эхний жилд ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал хийж гүйцэтгэх 27 үйлдлээс 15-аас доошгүй үйлдлийг хийж чаддаг болсоныг эмнэлзүйн удирдагч багш нотолсон үнэлгээ. Үнэгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж үнэлгээнд үндэслэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio assessment)

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд оролцсон сургалт, эрүүл мэндийн сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бичиг баримтыг цуглуулж өөрийн сургалтын хавтсанд хадгална.

7.4. Үнэлгээний дүнг хянах

Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд эмнэлзүйн сургагч багшийн өгсөн үнэлгээг сургалтын албанд хүлээлгэн өгч тэмдэглүүлнэ.

Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд нэгтгэн танилцуулж байна.

7.5. Сургалтын төгсгөлийг шийдвэрлэх

Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini-CEX, DOOPS, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, хөтөлбөрт заагдсан зайлшгүй хийх ажилбар, эмнэлзүйн тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана.

Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтанд оролцсон байх өдрийн тоо буюу ирц, сургалтын ирц хангалтгүй бол тасарсан сургалтын өдөр ба агуулгыг нөхүүлнэ.
- Сургалтын хугацаанд дараах энэлзүйн ажилбаруудыг хамгийн багадаа дараах тоогоор хийж гүйцэтгэсэн байна.

✓ Хэсгийн шахмал хуванцар шүдэлбэр	24 ш
✓ RPD	8 ш
✓ Бүрэн шүдэлбэр	4 ш
✓ Зоомол	2 ш
✓ Цутгамал голонцор	2 ш
✓ Цутгамал метал бүрээс	2 ш
✓ Метал шаазан бүрээс	4 ш
✓ Дан шаазан бүрээс	2 ш
✓ Гүүрэлсэн шүдэлбэр (3 нэгж)	2 ш
✓ Эрүүний үений эмчилгээний чиг	1 ш
- Суралцах хугацаанд дээрх эмнэлзүйн ажилбаруудын 2-оос доошгүй ажилбарыг багтаасан холимог эмнэлзүйн тохиолдол 1-ээс цөөнгүй удаа хэлэлцүүлсэн байна.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалт эрхлэгч байгууллагын сургалтын албаны дарга, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд дарга, Нүүр Амны Согог Заслын Тасаг, сувилахуйн албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ.
- Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн даргын шууд удирдлага дор ажиллана.

- Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэлзүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж, хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл Мэндийн Хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

Хавсралт 1

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

..... он.....сар.....

Суралцагч эмчийн нэр.....

Үнэлгээ хийгч: () эмнэлзүйн сургагч багш () сувилагч () бусад

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийн ажигласнаар оноо тавина уу.

Тухайн асуултад үнэлгээ авах боломжгүй бол 0

Тухайн асуултыг 19% биелүүлсэн бол 1;

20-49% биелүүлсэн бол 2;

50-79% биелүүлсэн бол 3;

80-аас дээш биелүүлсэн бол 4 гэсэн үнэлгээ өгнө.

1. Эмнэлгийн ажилтантай харилцах хандлага: хүндэтгэлтэй, харилцан ойлголцож харилцаж байгаа байдал

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

2. Үйлчлүүлэгчтэй харилцах хандлага: итгэл найдвартай, үйлчлүүлэгчдийн эрх болон хийх эрхийг хүндэтгэн үздэг эсэх

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

3. Найдвартай нягт нямбай байдал

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

4. Харилцааны ур чадвар: үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлтэй харьцах

1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй	Хангалттай	Маш сайн						
5.	Харилцааны ур чадвар: эмнэлгийн мэргэжилтэн, ажилтантай харьцах							
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй	Хангалттай	Маш сайн						
6.	Багаар ажиллах ур чадвар: хариуцлагатай, шуурхай, нэгнээ дэмжих байдал							
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй	Хангалттай	Маш сайн						
7.	Манлайлах ур чадвар: өөрийн болоод багийн хийж буй ажилд хариуцлагатай, идэвхтэй оролцох							
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй	Хангалттай	Маш сайн						
8.	Ерөнхий харьцаа, хандлагын байдал							
1	2	3	4	5	6	7	8	9
Хангалтгүй	Хангалттай	Маш сайн						

1 эсвэл 4 оноо өгсөн бол шалтгаанаа бичнэ үү

- 1.
- 2.
- 3.

Хавсралт 2

ЯВЦЫН (Mini-CEX) ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

.....он.....сар.....

Суралцагч эмчийн нэр..... Үнэлэгчийн нэр.....

Сургалт эрхлэх байгууллага: нэгж

Өвчтөний нас эр эм

Шалгалт авсан орчин (доогуур нь зур): Тасагт, амбулаторид, стандарт өвчтөн, бусад

Үйлчлүүлэгчийн нас, хүйс: эр/эм (доогуур нь зур)

Үзлэг(доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал(доогуур нь зур): хүнд, дунд зэрэг, хөнгөн

Шалгалтын зорилго:

Өвчтөний зовиур: Шинж тэмдэг (signs and symptoms)

1. Асуумж авах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

2. Бодит үзлэг хийх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

3. Эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)
 1 2 3 4 5 6 7 8 9
 Хангалтгүй Хангалттай Маш сайн
4. Зөвлөгөө өгөх ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)
 1 2 3 4 5 6 7 8 9
 Хангалтгүй Хангалттай Маш сайн
5. Үр дүнтэй зохион байгуулах ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)
 1 2 3 4 5 6 7 8 9
 Хангалтгүй Хангалттай Маш сайн
6. Үйлчлүүлэгчид тавьж буй анхаарал, хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)
 1 2 3 4 5 6 7 8 9
 Хангалтгүй Хангалттай Маш сайн
7. Ерөнхий эмнэлзүйн ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)
 1 2 3 4 5 6 7 8 9
 Хангалтгүй Хангалттай Маш сайн

Шалгагч багшийн зүгээс Mini-CEX үнэлгээнд өгөх сэтгэл ханамж:
 (1-9 оноог өгнө)

Тэмдэглэл:

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг..... Суралцагчийн гарын үсэг.....

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд

Өвчний өгүүлэмж авах	Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу үзүүлдэг Өвчтөнийг бүрэн ойлгож, тодорхой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Оношилгоо эмчилгээний менежмент	Зөв онош тавьдаг Оношилгоо эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг Тохирсон эмчилгээ эхлүүлдэг Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг
Харилцааны ур чадвар	Өвчтөн түүний гэр бүл, асран хамгаалагч хүнийг сайн сонсдог Тэдний зовиолыг хуваалцаж хүндэтгэлтэй ханддаг Тэдэнтэй эелдэг харилцаж, энгийн үг хэллэг хэрэглэн зөвөлгөө өгдөг
Эмнэлзүйн ур чадвар	Системтэй, харилцан уялдаатай арга замыг сонгодог Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргадаг “Би гэр бүлийнхээ нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна”

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS) -ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

.....он.....сар.....

Суралцагч эмчийн нэр.....

Үнэлэгчийн нэр.....

Сургалт эрхлэх байгууллага:

Шалгалт авсан орчин (доогуур нь зур): Тасагт, амбулаторид, стандарт өвчтөн, бусад

Үйлчлүүлэгчийн нас, хүйс: эр/эм (доогуур нь зур)

Үзлэг(доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал(доогуур нь зур): хүнд, дунд зэрэг, хөнгөн

Гардан үйлдлийн нэр:

1. Хийж буй үйлдлийн техник болоод холбогдох ойлголтуудыг мэдэж буй байдал
(ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

2. Үйлчлүүлэгчээс холбогдох зөвшөөрлийг авсан эсэх
(ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

3. Гардан үйлдлийн өмнөх бэлтгэл ажил (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

4. Тайвшруулах ба сэтгэц нөлөөт эм бэлдмэлийг зөв сонгож, тун зөв эсэх, бэлтгэх
(ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

5. Техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

6. Халдваргүйжүүлэх техник ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

7. Зөв зохистой тусламж үйлчилгээг үзүүлэх ур чадвар
(ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

8. Гардан үйлдлийн дараах менежмент (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

9. Харилцааны ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

10. Өвчтөнд тавьж буй анхаарал ба хүнлэг байдал (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

11. Үйлдлийг гүйцэтгэх ерөнхий ур чадвар (ажиглагдаагүй бол 0 оноо)

1 2 3 4 5 6 7 8 9

Хангалтгүй Хангалттай Маш сайн

Суралцагч эмч өнөөдрийг хүртэл хугацаанд тухайн гардан үйлдлийг хийсэн (.....)

№	Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Үнэлгээ өгөх боломжгүй
1	Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг				
2	Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг				
3	Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг				
4	Арга зүйг стандарт удирдамжийн дагуу чадварлаг гүйцэтгэдэг				
5	Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг				
6	Үйлдлийн дараа багаж хэрэгслийг цэвэрлэдэг				
7	Шаардлагатай бичиг баримтыг гүйцэд бичдэг				
8	Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

Сайн тал:

Сайжруулах тал:

Бусад санал:

Үнэлэгчийн гарын үсэг.....

Суралцагчийн гарын үсэг

НОМ ЗҮЙ

1. Н.Пүрэвжав, Б.Отгонбаяр, Б.Сапаар, П.Жавхлан, Ч.Гантөмөр, Э.Сүхбаатар, П.Зөнбилэгт. Нүүр амны согог гажиг заслын эмнэл зүй. УБ хот. 2005, 2009, 2015, 2020 он
2. Б.Сапаар, С.Дэжидноров, Г.Мөнхжаргал Нүүр амны материал судлал. УБ хот. 2021 он
3. S Lakshmi. Preclinical Manual of Prosthodontics. Elsevier 2020
4. V Rangarajan, TV Padmanabhan. Textbook of Prosthodontics. Elsevier 2018
5. Peter E Dawson. Functional Occlusion: From TMJ to Smile Design. Elsevier 2007
6. Rosenstiel, Land, Fujimoto CONTEMPORARY FIXED PROSTHODONTICS. Elsevier 2006
7. Kratochvil's Fundamentals of Removable Partial Dentures. Quintessence Publishing Co, Inc 2019
8. McCracken's REMOVABLE PARTIAL PROSTHODONTICS Elsevier 2013
9. Arthur O. Rahn, John R. Ivanhoe, Kevin D. Plummer Textbook of Complete Dentures. People's Medical Publishing House 2020
10. Michael I. MacEntee The Complete Denture: A Clinical Pathway. Vancouver, Canada 2020
11. Carl E Misch. CONTEMPORARY IMPLANT DENTISTRY. Elsevier 2018
12. Jeffrey P. Okeson. Management of Temporomandibular Disorders and Occlusion. Elsevier inc, 2020